



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/2/СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: Tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn</p>
--	--

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь/	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Хавсралт-Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор аймгийн Хөдөлмөр
Эрхлэлтийг Дэмжих Сангийн
Төсвийн Захирагч Д.Амарсанаа

2021.02.18 № 2/48
танай _____ -ны № _____ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

2021 А4 ТООТ



удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛӨХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1758053163.00	1843889945.00
33	АВЛАГА	1758053163.00	1843889945.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	24086420.00	6117795.00
33400	Зээлийн хүүгийн авлага	1733966743.00	1837772150.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1758053163.00	1843889945.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	41051700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	41051700.00
413	Өглөг	0.00	41051700.00
4136	Бусад өглөг	0.00	41051700.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		41051700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1758053163.00	1802838245.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1758053163.00	1802838245.00
512	Хуримтлагдсан үр дүн	1758053163.00	1802838245.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1758053163.00	1758053163.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	44785082.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1758053163.00	1843889945.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1344796895.00	1103351672.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104796895.00	156312572.00
120	Нийтлэг татварын бус орлого	4796895.00	156312572.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4796895.00	156312572.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4796895.00	156312572.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100000000.00	0.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	100000000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1240000000.00	947039100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1240000000.00	387605950.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1240000000.00	387605950.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	559433150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	30759050.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		100000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	428674100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	930256396.00	1058566590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930256396.00	1058566590.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	66697100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	3032100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	3032100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	63665000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	50752000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	12913000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	926256396.00	991869490.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	581759730.00	442687105.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	581759730.00	442687105.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4796895.00	160012572.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4796895.00	156312572.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3700000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	24086420.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	24086420.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	339699771.00	365083393.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	339699771.00	365083393.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	414540499.00	44785082.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	414540499.00	44785082.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1728342816.00	1474546265.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	468571666.00	527507165.00
120	Нийтлэг татварын бус орлого	368571666.00	527507165.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	368571666.00	527507165.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	363774771.00	371194593.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4796895.00	156312572.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100000000.00	0.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	100000000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1259771150.00	947039100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1259771150.00	387605950.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1240000000.00	387605950.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	19771150.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	559433150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	30759050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		100000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	428674100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1728342816.00	1474546265.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1728342816.00	1474546265.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	66697100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	3032100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	3032100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	63665000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	50752000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	12913000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1724342816.00	1407849165.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1355759730.00	876635405.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1355759730.00	876635405.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4796895.00	160012572.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4796895.00	156312572.00
213305			3700000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11420.00	6595.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11420.00	
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		6595.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	363774771.00	371194593.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	363774771.00	371194593.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	0.00	1,758,053,163.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	0.00	1,758,053,163.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	0.00	1,758,053,163.00
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	0.00	1,758,053,163.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	0.00	1,758,053,163.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	44,785,082.00	0.00	44,785,082.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,802,838,245.00	0.00	1,802,838,245.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1218304100.00	387605950.00	830698150.00	31.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1218304100.00	387605950.00	830698150.00	31.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70397100.00	37605950.00	32791150.00	53.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3032100.00	1000000.00	2032100.00	33.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3032100.00	1000000.00	2032100.00	33.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67365000.00	36605950.00	30759050.00	54.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54452000.00	23692950.00	30759050.00	43.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12913000.00	12913000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1144407000.00	350000000.00	794407000.00	30.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1144407000.00	350000000.00	794407000.00	30.6

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1144407000.00	350000000.00	794407000.00	30.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1218304100.00	915113115.00	303190985.00	75.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1147439100.00	351000000.00	796439100.00	30.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1147439100.00	351000000.00	796439100.00	30.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3500000.00	527507165.00	-524007165.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		371194593.00	-371194593.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3500000.00	156312572.00	-152812572.00	
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	67365000.00	36605950.00	30759050.00	54.3
122002	Хандив тусламж /гадаад/	67365000.00	36605950.00	30759050.00	54.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		555,726,555.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		555,726,555.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		29,091,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,032,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,032,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		27,059,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		27,059,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		526,635,405.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		526,635,405.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		526,635,405.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Д.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 20-ний өдрийн 111 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг өргөжүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргаа, хяналтын хэлтсээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2020 оны 1-р улирлыг хамруулан шалгалт хийсэн байна

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 622,268.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6222.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,058,566.6 мянган төгрөгийн 1 хувь буюу 10585.7 мянган төгрөгөөр тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,843,889.9 мянган төгрөг болж өмнөх оноос 85,836.8 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / мянган төгрөг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,758,053.2	1,843,889.9	85,836.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,758,053.2	1,843,889.9	85,836.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-	-
Нийт хөрөнгө	1,758,053.2	1,843,889.9	85,836.8
Өр төлбөр	-	41,051.7	41,051.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,758,053.2	1,802,838.2	44,785.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,758,053.2	1,843,889.9	85,836.8

Эх сурвалж: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 1,843,889.9 мянган төгрөг болж 85,836.8 мянган төгрөгөөр өссөн нь дэлхий нийтэд тархаад буй Ковид 19 цар тахлын үед иргэдийн орлого буурч, зээл төлөх төлбөрийн чадвар муудсанаас шалтгаалсан байна.

Мөн тайлант онд 41,051.7 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан нь цар тахлын онцгой нөхцөл нөхцөлийн улмаас улсын төсөв хүндэрсэн учир Сангийн яамны Төрийн сангийн газар нь санхүүжилтийг олгох боломжгүй болсноос шалтгаалж аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтэст өр төлбөр үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,802,838.2 мянган төгрөг болж 44,785.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардлаас шалтгаалжээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,103,351.7 мянган төгрөг болж өмнөх оноос 241,445.2 мянган төгрөгөөр буюу 21.9 хувиар буурсан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан санхүүжилтийг 367,765.0 төгрөгөөр дутуу хуваарилснаас шалтгаалсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн орлогыг 3500.0 мянган төгрөгөөр баталсан ч гүйцэтгэлээр 156,312.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Нийт зардал 1,058,566.9 мянган төгрөг болж өмнөх оноос 128,310.2 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар өссөн нь бараа үйлчилгээний урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,511,093.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,511,093.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,828,836.5 мянга буюу 317,743.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийг 714,047.5 мянган төгрөгөөр нэмж баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 1,828,836.5 мянган төгрөгийн төсөв баталж, 3 удаа тодотгож улсын төсвөөс 1,147,439.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3500.0 мянга, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар 67,365.0 мянга төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 779,674.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаас 67,365.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс 156,312.6 мянга, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 371,194.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 943,332.5 мянган төгрөгийг зарцуулж, 531,213.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 387,605,9 мянган төгрөг буюу 30.6 хувьтай байгаа нь Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын 2020.06.03-ны өдрийн 8/1034 тоот албан бичгээр 2020 оны 06 дугаар сараас эхлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын дэргэд нэмэлт санхүүжилтийн данс нээлгэж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг нээлгэсэн бөгөөд уг дансаар санхүүжилтийн орлого болох 350,000.0 мянган төгрөг төвлөрч, зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт2: Төсөв зардлыг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хөтөлбөр 72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
Арга хэмжээ 80110-Гадаад зээл, тусламжийн ТЕЗ-д шилжих ажил үйлчилгээ					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
12	Татварын бус орлого	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.3
Хөтөлбөр 72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
Арга хэмжээ 80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
12	Татварын бус орлого	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,032,100.00	1,000,000.00	2,032,100.00	32
Хөтөлбөр 72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
Арга хэмжээ 82616-ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,144,407,000.00	350,000,000.00	794,407,000.00	30.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,144,407,000.00	350,000,000.00	794,407,000.00	30.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,144,407,000.00	350,000,000.00	794,407,000.00	30.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,144,407,000.00	350,000,000.00	794,407,000.00	30.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,214,804,100.00	387,605,950.00	794,407,000.00	30.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,147,439,100.00	351,000,000.00	796,439,100.00	30.59
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,147,439,100.00	351,000,000.00	796,439,100.00	30.59
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.34
122002	Хандив тусламж /гадаад/	67,365,000.00	36,605,950.00	30,759,050.00	54.34

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын 2020.06.03-ны өдрийн 8/1034 тоот албан бичгээр 2020 оны 06 дугаар сараас эхлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын дэргэд нэмэлт санхүүжилтийн данс нээлгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг Сангийн яамны болон нийслэл, аймаг, дүүргийн төрийн сангуудаар дамжуулан нээлгэсэн байна.

Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн орлого, бусад орлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн урсгал санхүүжилтийн дансаар бүртгэх, эдгээр орлогыг 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор төвлөрүүлсэн байх заавар чиглэл иржээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд туршилтын хөтөлбөрийн санхүүжилтээс 30,759.0 мянга, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээс 427,642.0 мянга, аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/345 дугаар захирамжаар “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдах малчдад зориулж 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргаа, хяналтын хэлтсээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2020 оны 1-р улирлыг хамруулан шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих сан нь хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.6, 6.4.3, 6.4.6, 6.10-д заасан мэдээллийг байршуулаагүй байсныг зөвлөмж өгч, нөхөж байршуулсан байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 86 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 7 мэдээлэл байна. Хуулийн 6.5.4-д заасан мэдээллийг хугацаандаа мэдээлсэн харагдаж байгаа ч зарим сарын гүйлгээг орхигдуулж мэдээлсэн байна. Тухайлбал: 4,6,7,8,10 дугаар саруудад 334,815.5 мянган төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 3,4,5,6,7,8,9,12, дугаар саруудад 1,287,978.1 мянган төгрөгийн зарлагын 46 гүйлгээ, нийт 1,622,793.6 мянган төгрөгийн 55 гүйлгээг тус тус мэдээлээгүй, мөн хагас жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны

Хүснэгт 3: Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуул аагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	0	2
2	Хагас жил	4	4	2	1	1	
3	Улирал бүр	1	4	4	0		
4	Сар бүр	3	36	33	3		
5	Тухай бүр	8	96	39	2	55	
6	Нийт	27	151	86	7	56	2

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”; 6.5.4-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”- д заасныг тус тус зөрчиж байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 154,481.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлснийг Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2020.06.09-ний өдрийн 512 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	154481.0	2	154481.0	-	-	-
Нийт дүн	2	154481.0	2	154481.0	-	-	-

Эх сурвалж: Статистик мэдээ

3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 319,290.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 705.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, зөрчлийг арилгах албан шаардлага 1, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 318,585.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 705.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 705.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 1 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

1. "Хонгорын багачууд" ТББ болон Гурванбулаг сумын ЗДТГ-ын дарга нь аймгийн ХХҮГ-ын даргатай гэрээ байгуулан нийтийг хамарсан ажил зохион байгуулсан бөгөөд уг ажлын зорилго нь ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах атал "Хонгорын багачууд" ТББ -ын нийтийг хамарсан ажилд оролцсон байнгын ажлын байртай 2 хүнд тус бүр 252.0 мянга, мөн Гурванбулаг сумын 3-р багийн Засаг даргын албан тушаалтай 1 иргэнд 201.6 мянга, нийт 705.6 мянган төгрөгийн цалинг бодож олгосон зөрчил илэрсэн нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1-р тогтоолын 2-р хавсралт "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 8.3, 8.4 дэх заалтыг зөрчиж, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1 Шийдвэрлэсэн нь: Нийтийг хамарсан ажилд хамрагдсан байнгын ажлын байртай 3 иргэнд олгосон цалинг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх **төлбөрийн акт** тогтоох.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 4,6,7,8,10 дугаар саруудад 334,815.5 мянган төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 3,4,5,6,7,8,9,12, дугаар саруудад 1,287,978.1 мянган төгрөгийн зарлагын 46 гүйлгээ, нийт 1,622,793.6 мянган төгрөгийн 55 гүйлгээг тус тус мэдээлээгүй, мөн хагас жилийн санхүүгийн тайланг цахим хуудаст байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.4, 6.4.5 дахь заалтыг зөрчиж, "Иж бүрэн байх", "Үнэн ба зөв" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2 Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хуулийн 6.4.5, 6.4.1-д заасан мэдээллүүдийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 318,585.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авлагын дансыг авч үзэх



Нийт авлагыг насжилтаар нь авч үзвэл 1 хувийг 5-с дээш жилийн насжилттай, 11% хувийг 4 жилийн насжилттай, 24%-ийг 3 жилийн насжилттай авлага эзэлж байна. Нийт хугацаа хэтэрсэн 319 иргэн, ААНБ-ын 575,956.6 мянган төгрөгийн авлагын 188,733.8 мянган төгрөг буюу 32.8 хувийг шүүхийн байгууллагад хандсан бөгөөд тайлант онд Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.03.04-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн

эзэн" аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн хавсралтад заасан 295 өрхийн орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр 2017, 2018, 2019 онд санхүүжүүлсэн 287600.0 мянган төгрөгийн авлагыг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарсан ч одоогоор уг тогтоолын дагуу арга хэмжээ аваагүй байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 07 дугаар тогтоолоор иргэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацааг холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 2021.07.01-ний өдрийг хүртэл хойшлуулах талаар чиглэл ирүүлсэн байна.

Хүснэгт: 5 Авлагын насжилт

Хөтөлбөр арга хэмжээ	1 жил	2 жил	3 жил	4 жил	5-с дээш жил	Нийт авлага
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	218,514,000.00	199,298,214.00	59,561,445	44,680,000.00	3,112,800.00	525,166,459.00
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр		144,858,000.00	60,550,000.00	13,660,000.00		219,068,000.00
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	28,092,760.00	39,032,072.00	28,120,464.00	28,575,000.00		123,820,296.00
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	195,000,000.00	301,100,000.00	215,928,000.00	122,781,000.00	4,500,000.00	839,309,000.00
зөвлөх үйлчилгээг	27,600,000.00	20,550,000.00	2,800,000.00			50,950,000.00
Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл			79,458,395.00			79,458,395.00
Нийт авлагын насжилт	469,206,760.00	704,838,286.00	446,418,304.00	209,696,000.00	7,612,800.00	1,837,772,150.00

Эх сурвалж: ХЭДС-аас ирүүлсэн судалгаа

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

- 1.1. Илрүүлэлт: Тайлант оны нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардлыг түүвэрлэн үзэхэд байнгын ажлын байраар хангагдсан иргэдэд цалин олгосон зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1-р тогтоолын 2-р хавсралт "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 8.1, 8.3, 8.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.
- 1.2. Эрсдэл: Холбогдох хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөж, хөрөнгө завших.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1-р тогтоолын 2-р хавсралт "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 8.1, 8.3, 8.4 дэх заалтыг хэрэгжүүлж, аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийг нийтийг хамарсан ажилд ажиллуулж цалинг олгож, түр ажлын байраар хангаж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2. *Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл*

- 2.1. Илрүүлэлт: Тайлант хугацааны ажилд зуучлах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээтэй тулган баталгаажуулахад 610.0 төгрөгийн илүү зардал гаргасан байна.
- 2.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх, хөрөнгө завших.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/164 тоот тушаалын хавсралтын дагуу мэдээ тайланг үнэн зөв гаргаж, цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг нормативыг мөрдөж ажиллах.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3. *Балансын данстай холбоотой*

- 3.1. Илрүүлэлт: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан зарим иргэн, аж ахуйн нэгж байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлийг давхардуулан авсан байна. Тухайлбал: 2019 онд ажлын

байрыг дэмжих хөтөлбөрөөс 2 иргэн 8000.0 мянга, 2020 онд 1 иргэн 3000.0 мянга, 2019 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес эрхлэх хөтөлбөрөөс 1 иргэн 9375.0 мянга, 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 1 иргэн 1500.0 мянга, 2017 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд 1 иргэн хамрагдаж 8500.0 мянган төгрөгийг тус тус давхардуулан авсан байна.

3.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх, иргэн ААНБ зээлийн эрсдэлд орох, зээл чанаргүй болж хугацаандаа төлөгдөхгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол “ Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих” журмын 1.4.2-д “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23.6-д заасан болон Сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй” иргэн, ААНБ-д зээл олгохгүй байх гэсэн заалтыг дагаж мөрдөх, мөн төсөл сонгон шалгаруулах комисс нь ирүүлсэн төслийг шалгаруулахдаа сум хөгжүүлэх сан болон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнээс зээлийн лавлагаа авч цаашид уялдаа холбоотой ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

4. Балансын данстай холбоотой

4.1. Илрүүлэлт: Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.03.04-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн эзэн" аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн хавсралтад заасан 295 өрхийн орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр 2017,2018,2019 онд санхүүжүүлсэн 287600.0 мянган төгрөгийн авлагыг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарсан ч тухайн байгууллагын дарга холбогдох шийдвэрийг гаргаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн авлагыг бууруулаагүй байна.

4.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх, иргэн, зээл чанаргүй болох.

4.3. Өгсөн зөвлөмж: Аймгийн орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 2017, 2018, 2019 онуудад малжуулахаар олгосон 287,600.0 мянган төгрөгийн зээлийн авлагыг хууль, журамд нийцүүлэн арга хэмжээ авч ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Бэлтгэсэн:

АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ
Огноо: 2021.02.18

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.18



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			БНА-2021/2/СТА-ОНТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	“Хонгорын багачууд” ТББ болон Гурванбулаг сумын ЗДТГ-ын дарга нь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргатай гэрээ байгуулан нийтийг хамарсан ажил зохион байгуулсан бөгөөд уг ажлын зорилго нь ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах атал “Хонгорын багачууд” ТББ -ын нийтийг хамарсан ажилд оролцсон байнгын ажлын байртай 2 хүнд тус бүр 252.0 мянга, мөн Гурванбулаг сумын 3-р багийн Засаг даргын албан тушаалтай 1 иргэнд 201.6 мянга, нийт 705.6 мянган төгрөгийн цалинг бодож олгосон байна.	705.6	Төлбөрийн акт	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд	Д.Амарсанаа, А.Өлзийжаргал, Д.Алтанцэцэг, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан 4,6,7,8,10 дугаар саруудад 334,815.5 мянган төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 3,4,5,6,7,8,9,12, дугаар саруудад 1,287,978.1 мянган төгрөгийн зарлагын 46 гүйлгээ, нийт 1,622,793.6 мянган төгрөгийн 55 гүйлгээг тус тус мэдээлээгүй, мөн хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.	0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг
3	Тайлант оны нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардлыг түүвэрлэн үзэхэд байнгын ажлын байраар хангагдсан иргэдэд цалин олгосон зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1-р тогтоолын 2-р	0	Зөвлөмж өгөх	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, ХЭДС хариуцсан	Д.Амарсанаа, А.Өлзийжаргал, Д.Алтанцэцэг, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хавсралт "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 8.1, 8.3, 8.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.			ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүү Д	
4	Тайлант хугацааны ажилд зуучлах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээтэй тулган баталгаажуулахад 610.0 төгрөгийн илүү зардал гаргасан байна.	610.0	Зөвлөмж өгөх	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүү Д	Д.Амарсанаа, А.Өлзийжаргал, Д.Алтанцэцэг, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир
5	ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан зарим иргэн, аж ахуйн нэгж байгууллага ХЭДС-ийн зээлийг давхардуулан авсан байна. Тухайлбал: 2019 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 2 иргэн 8000.0 мянга, 2020 онд 1 иргэн 3000.0 мянга, 2019 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес эрхлэх хөтөлбөрөөс 1 иргэн 9375.0 мянга, 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 1 иргэн 1500.0 мянга, 2017 онд ХЭДС-ийн жижиг зээлд 1 иргэн хамрагдаж 8500.0 мянган төгрөгийг тус тус давхардуулан авсан байна.	30,375.0	Зөвлөмж өгөх	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүү Д	Д.Амарсанаа, А.Өлзийжаргал, Д.Алтанцэцэг, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир
6	Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.03.04-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн эзэн" аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн хавсралтад заасан 295 өрхийн орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр 2017,2018,2019 онд санхүүжүүлсэн 287600.0 мянган төгрөгийн авлагыг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарсан ч тухайн байгууллагын дарга холбогдох шийдвэрийг гаргаж ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн авлагыг бууруулаагүй байна.	287,600.0	Зөвлөмж өгөх	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүү Д	Д.Амарсанаа, А.Өлзийжаргал, Д.Алтанцэцэг, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир
ДҮН		319,290.6			